



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

**ОРХОНТУУЛ СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЭЭЛЖИТ
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ МОНГОЛ АРДЫН
НАМД**

2024.08.05 № ГНДТ-2024/13-УТ/АНА-09

танай _____-ны № _____-т

**Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-т заасан төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Орхонтуул сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Монгол Ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Орхонтуул сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь 2024 оны аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын

нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

Монгол Ардын намын Орхонтуул сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт арга, хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Орхонтуул сумын Монгол Ардын намын мөрийн хөтөлбөр (06 хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Орхонтуул сумын Сонгуулийн хороонд


ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

**ОРХОНТУУЛ СУМЫН ИТХ-ЫН 2024 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД ОРХОНТУУЛ
СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРООНООС ДЭВШҮҮЛЖ БУЙ
МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

2024.06.23



**ОРХОНТУУЛ САЙХАН НУТГАА
“ХАМТДАА ХӨГЖҮҮЛЬЕ”**

Монгол Улсын хөгжлийн “Алсын хараа 2050”-ийг үндсэн чиглэл болгон Сэлэнгэ аймгийн Монгол Ардын Намаас Аймаг, сумын ИТХ-ын 2024 оны сонгуульд дэвшүүлсэн хөгжлийн зорилтуудыг орон нутагтаа хэрэгжүүлэх, Орхонтуул нутгийнхаа хөгжлийг шинэ шатанд гаргах зорилгоор сум, орон нутгийнхаа ард иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус байгууллагуудаас мөрийн хөтөлбөрт тусгуулахаар ирүүлсэн саналуудыг нягтлан үзэж, нэгтгэн дүгнэж, сумынхаа нийгэм, эдийн засгийн хөгжлийн өнөөгийн байдалд тулгуурлан, Орхонтуул сумын Монгол Ардын Намын Хорооноос 2024-2028 онд Орхонтуул сумын хөгжил, дэвшил, хүн ардынхаа сайн сайхны төлөө хийж, хэрэгжүүлэх ажлаа хураангуйлан тусгасан мөрийн хөтөлбөрөө сонгогч олондоо өргөн барьж байна.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ЭРҮҮЛ МЭНД

- 1.1. Эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрт иргэдийг бүрэн, тэгш хамруулж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 1.2. Сумын хүн амын дунд зонхилон тохиолдож байгаа өвчлөл, эндэгдлийн шалтгааныг судлан тогтоох, урьдчилан сэргийлэх, оношлох, эмчлэхэд эрүүл мэндийн салбарын үйлчилгээг чиглүүлнэ.
- 1.3. Иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг шуурхай, чирэгдэлгүй болгож үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.
- 1.4. Сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдэд эрүүл мэндийн үзлэгийг тогтмол зохион байгуулж, эрт илрүүлэх, эрүүлжүүлэх ажлыг чанаржуулна.
- 1.5. Эрүүл мэндийн байгууллагуудын барилгын засвар, туслах барилгуудыг ашиглалтад оруулан, тохижилт, өргөтгөл, үйлчилгээг үе шаттайгаар хэрэгжүүлж, техник хэрэгслээр ханган, иргэдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг бүх түвшинд шуурхай хүргэх, ая тухтай орчинд оношлох, эмчлэх боломжийг бүрдүүлнэ.
- 1.6. Сумын эрүүл мэндийн салбарт дутагдалтай, нарийн мэргэжлийн эмчээр амжилттай суралцаж байгаа, сургуулиа төгсөөд орон нутагтаа ирж ажиллах Орхонтуул сумын харьяат оюутанд олгох дэмжлэгийг бий болгоно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. БОЛОВСРОЛ

- 2.1. Өсвөр үеийнхнийг эх оронч үзэлтэй, их түүхээ судалж, уламжлалт өв соёлоо дээдэлсэн, “Зөв хүн” болгон төлөвшүүлэх, бага, дунд боловсролын чанарыг дээшлүүлэхэд боловсролын байгууллагуудын үйл ажиллагааг чиглүүлж, хүүхдийн өөрийнх нь авьяаст тулгуурлан хөгжүүлж, амьдралын зөв дадалд сургана.
- 2.2. Бага, дунд боловсролын сургалтын чанарт жил бүр хөндлөнгийн хяналт хийж, эцэг эхчүүдэд танилцуулж, үнэлүүлдэг болно.
- 2.3. Цэцэрлэг, сургуулийн орчныг бүрэн камержуулж, хүүхдийн аюулгүй, таатай суралцах орчныг бүрдүүлнэ.

- 2.4. Ерөнхий боловсролын сургуулиудыг дотуур байрыг шаардлага хангасан ундны цэвэр усаар хангаж, ариун цэврийн болон угаалгын өрөөтэй болгон, галын стандарт шаардлагыг хангуулж, хүүхдэд ээлтэй, эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлнэ.
- 2.5. Орон нутагт дутагдалтай мэргэжлээр өөрийн хүсэлтээр шилжин ирж ажиллах багшид олгох дэмжлэгийг бий болгоно.
- 2.6. Орон нутагт дутагдалтай багшийн мэргэжлээр амжилттай суралцаж байгаа, сургуулиа төгсөөд орон нутагтаа ирж ажиллах Орхонтуул сумын харьяат оюутанд олгох дэмжлэгийг бий болгоно.
- 2.7. Тусгай хэрэгцээт хүүхдийг сургууль, цэцэрлэгт сурч хөгжих боломж, нөхцөлийг бүрдүүлнэ.
- 2.8. Ерөнхий боловсролын сургуулиудын дунд болон хамтын ажиллагаатай аймаг, сумын багш, сурагч солилцооны хөтөлбөрүүдийг боловсруулан хэрэгжүүлнэ.
- 2.9. Ерөнхий боловсролын сургуулиудын кабинетуудыг шат дараатайгаар хөгжүүлж, суралцагчдын суралцах нөхцөлийг бүрдүүлнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. СОЁЛ, УРЛАГ

- 3.1. “Соёлч иргэн”, “Соёлч гудамж”, “Соёлч хамт олон” зэрэг хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн аж ахуйн нэгж, байгууллагууд сар бүр соёлын ажлыг зохион байгуулдаг тогтмол өдөртэй болж, иргэдийн идэвх санаачилга дээр тулгуурлан хот, суурингийн соёлыг дэлгэрүүлнэ.
- 3.2. Соёлын төвүүдийн номын сан, орон нутаг судлах танхимын үзмэр, сан хөмрөгийг баяжуулж, үйлчилгээ, сурталчилгааны чанарыг дээшлүүлнэ.
- 3.3. Соёлын биет бус өв, язгуур урлагийн шавь сургалтыг бий болгосон бүлэг, хамт олон, өвлөн уламжлагчдыг дэмжиж, урамшуулах тогтолцоог бий болгоно.
- 3.4. Соёл урлагийн байгууллагуудын барилгын засвар, тохижилт, хөгжим аппаратур, тоног төхөөрөмжөөр хангах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж, иргэд ая тухтай орчинд үйлчлүүлэх боломжийг дээшлүүлнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. БИЕЙН ТАМИР, СПОРТ

- 4.1. Иргэдийг идэвхтэй хөдөлгөөн, нийтийн биеийн тамир спортоор хичээллэх сонирхлыг төрүүлэх, орчныг бүрдүүлэх, сайжруулах, эрүүл чийрэг амьдралыг төлөвшүүлэхэд биеийн тамир, спортын салбарын үйлчилгээг чиглүүлнэ.
- 4.2. Сумын иргэдийн дунд “Сумын Засаг даргын нэрэмжит” спортын олон төрөлт тэмцээнийг жил бүр зохион байгуулна.
- 4.3. Төрийн албан хаагчдын дунд спортын олон төрөлт тэмцээнийг жил бүр зохион байгуулна.
- 4.4. Сумын хэмжээнд үндэсний сур, шагайн харвааг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- 4.5. Нийтийн биеийн тамир дасгал хөдөлгөөнийг түгээн дэлгэрүүлэх ажлыг эрчимжүүлж, ахмад настан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хамрагдалтыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна.

ТАВДУГААР БҮЛЭГ. АМЬДРАЛЫН ТААТАЙ ОРЧИН

- 5.1. Ногоон байгууламжийн талбайн хэмжээг нэмэгдүүлэх, цэцэрлэгжүүлэх, хамгаалахад иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.
- 5.2. Сумын төв болон Рашаант тосгоны үерийн хамгаалалтын далан, хур тунадасны ус зайлуулах суваг, хоолойг байгуулна.
- 5.3. Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах ажиллагааг хэвшүүлж, дахин боловсруулах, байгаль орчинд хор нөлөөгүй үйлдвэрийг байгуулах иргэдийн санаачилгыг дэмжинэ.

5.4. “Монгол улс дахь хуванцар хог хаягдлын дахин боловсруулалтын тогтвортой байдлыг хангах” төслийг хэрэгжүүлж, суманд “Хог хаягдал зохицуулах төв”-ийг байгуулах санхүүжилтийг холбогдох байгууллагад уламжлан шийдвэрлэнэ.

5.5. Сумдад хог хаягдлын төвлөрсөн цэгийн стандартын ландфиллын байгууламж, аюултай хог хаягдлыг түр хадгалах, устгах зориулалтын байгууламжийг үе шаттайгаар байгуулна.

5.6. Үлгэр дуурайлал болсон гэр бүлийг нийтэд сурталчлах, таниулах олон улсын гэр бүлийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлнэ.

5.7. Малчдын зуслан болон тариалангийн бригадын төвүүдэд харилцаа холбооны сүлжээ шинээр бий болгох ажлыг холбогдох ААН байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

6.1. Томоохон аж ахуйн нэгж, үйлдвэрийн нийгмийн хариуцлагын хүрээнд жижиг дунд үйлдвэрийг дэмжих санал санаачилгыг урамшуулж дэмжих замаар кластерийн хөгжлийг хангана.

6.2. Өрхийн аж ахуйн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжих, бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээ бий болгох ажлыг дэмжиж ажиллана.

6.3. Зорилтот бүлгийн өрхүүдийн амьжиргааг дэмжих төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

6.4. “Хөдөлмөр Зуслан” бий болгох замаар өсвөр үе, хүүхэд залуучуудыг хөдөлмөрт сургах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

ДОЛООДУГААР БҮЛЭГ. НИЙГМИЙН ХАМГААЛАЛ

7.1. Хүүхэд хамгааллын талаарх мэдлэг, ойлголт, хандлагыг нэмэгдүүлэх нөлөөллийн ажлыг хэрэгжүүлж, иргэдийн оролцоотой хүүхдийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

7.2. Гэр бүлийн хүчирхийллийг бууруулж, хүчирхийллийг үл тэвчих хандлагыг бий болгох нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлнэ.

7.3. Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, орлогыг нэмэгдүүлэх, мэдлэг туршлагаа залуучуудад өвлүүлж үлдээх боломжийг бүрдүүлнэ.

7.4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтцийн стандартыг бүх төрлийн орон сууц, худалдаа үйлчилгээний байгууллагуудад мөрдүүлнэ.

НАЙМДУГААР БҮЛЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ӨСӨЛТ

8.1. Хариуцлагатай уул, уурхай, дулааны хангамж

8.1.1. Сумын нутаг дэвсгэрт уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн лиценз эзэмшилтийг иргэдэд нээлттэй болгож, хууль зөрчиж олгосон зөвшөөрлийг хүчингүй болгуулах бодлогыг хэрэгжүүлж ажиллана.

8.1.2. Уул уурхайн нөхөн сэргээх ажлын хяналтыг сайжруулж, нөхөн сэргээлт хийгээгүй аж ахуйн нэгжид ногдуулах хариуцлагыг чангатгана.

8.2. Газар тариалан

8.2.1. Айл өрхүүдийг хүнсний зориулалттай болон жимс жимсгэнэ, мөөг зэрэг шинэ нэр төрлийн таримлын тариалалт, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэн, төвлөрсөн төмс хүнсний ногооны талбайн орчим шинэ суурьшлийн бүс бий болгож, цахилгаан эрчим хүчинд холбуулах ажлыг холбогдох байгууллага, аж ахуйн нэгжид уламжилж шийдвэрлэнэ.

8.2.2. Дөрвөн улирлын хүлэмж, агуулах, зоорийн аж ахуйг хөгжүүлэх замаар хүнсний ногоо, жимс жимсгэнийн нэр төрлийг нэмэгдүүлж, дотоодын хэрэгцээнд жилийн турш тогтвортой нийлүүлж, шинэ ургацын ногооны хангамжийг сайжруулна.

8.2.3. Газар тариалангийн салбарт ашиглаж байгаа эргэлтийн талбайн хөрсийг хамгаалах, үржил шимийг нэмэгдүүлэх талаар газар эзэмшигчийн хүлээх үүрэг, хариуцлагыг өндөржүүлнэ.

8.2.4 Төмс хүнсний ногоо эрхлэгчдийг дэмжих зорилгоор хүлэмжийн аж ахуй эрхлэлтийг дэмжиж, хүнсний ногооны техник дундын үйлчилгээг бий болгоно.

8.3. Мал аж ахуй

8.3.1. Сумын хэмжээнд бий болгосон малын үүлдэр, генийн санг хамгаалж, цөм сүргийг тогтвортой өсгөн малчин иргэдэд түгээн дэлгэрүүлж, малын ашиг шимийг нэмэгдүүлнэ.

8.3.2. Мал, амьтны өвчний гаралт, тархалтыг бууруулж, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлнэ.

8.3.3. Мал эмнэлгийн үйлчилгээний мэргэжлийн, шуурхай, нэгдмэл байдлыг хангах, мал эмнэлгийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

8.3.4. Дэвшилтэт технологи, техник бүхий эрчимжсэн мал аж ахуй, гахай, тахиа шувуу, зөгийн аж ахуйг шат дараатайгаар хөгжүүлэх иргэн, аж ахуйн нэгжийн гаргасан санал санаачилгыг дэмжинэ.

8.3.5. Малчид, тариаланчдын залгамж халааг бэлтгэх аяныг хэрэгжүүлнэ.

8.3.6. Бэлчээрийг усжуулах, худагжуулах ажлыг үргэлжлүүлэн, малын бэлчээрийг нэмэгдүүлнэ.

8.3.7. Цэцэрлэг, сургуулийн үдийн хоолонд сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлэх замаар малчдын орлогод дэмжлэг үзүүлнэ.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ. БАЙГАЛЬ ОРЧИН

9.1. Сумын нутаг дэвсгэрт үлийн цагаан оготнын тархцын судалгааг явуулж, бэлчээрт хөнөөл учруулж буй царцаа, үлийн цагаан оготно гэх мэт мэрэгч амьтадтай байгаль орчинд ээлтэй аргаар тэмцэнэ.

9.2. Уул уурхай, газар тариалан, дэд бүтцийн байгууламж, хот байгуулалт, бэлчээр ашиглалтын улмаас эвдрэл, доройтолд орсон газрыг нөхөн сэргээж, аж ахуйн зориулалтаар дахин ашиглах боломжтой болгон эргэлтэд оруулж, ашиглагчийн хариуцлагыг өндөржүүлнэ.

9.3. Хөрс хамгаалах, газрын доройтлыг бууруулах, цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангана.

9.4. Тэр бум мод хөтөлбөрийг хэрэгжүүлэх замаар сумын хэмжээнд мод бут, сөөг үржүүлэх, цэцэрлэгжүүлэх, орчныг хамгаалах зэрэг нийтэд тустай ажил үйлчилгээ эрхлэх иргэн, аж ахуйн нэгжийн гаргасан санал санаачилгыг бодлогоор дэмжиж ажиллана.

АРАВДУГААР БҮЛЭГ. ШУДАРГА ЗАСАГЛАЛ

10.1. Төр, иргэний нийгэм, хувийн хэвшлийн санаачилга, оролцоо, хамтын ажиллагааг дэмжинэ.

10.2. Төрийн аливаа шийдвэр гаргалтад хүний эрхийн мэдрэмжтэй хандаж, хүний эрхийг зөрчсөн шийдвэрийг цуцалж, төрийн хүнд суртлыг арилгана.

10.3. Төрийн нууцад хамаарахаас бусад бүх шийдвэр, тогтоол, гэрээ, хэлцэл, мэдээллийн санг хэвлэл, олон нийтэд нээлттэй, ил тод болгоно.

10.4. Төрийн үйл ажиллагаа, төсвийн зарцуулалт, орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдэд тавих иргэний болон хөндлөнгийн хяналтыг нэмэгдүүлж, мэдээллийг ил тод, нээлттэй байлгана.

10.5. Бүх нийтээр дагаж мөрдүүлэх хэм хэмжээний шийдвэрийг гаргахаас өмнө иргэд, иргэний нийгмийн байгууллагаар үнэлүүлдэг тогтолцоог бүрдүүлнэ.

10.6. Төрийн албан хаагчийн ёс зүй, хандлагыг ажлын гүйцэтгэлийн үнэлгээний чухал хэсэг болгон хэвшүүлж, үйлчилгээний соёлыг дээшлүүлнэ.

10.7. Хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөрөөр хэрэгжиж байгаа ажил, арга хэмжээнд дотоод хяналтыг чанартай гүйцэтгэж, үр дүнг олон нийтэд тогтмол мэдээлнэ.

10.8. Төрийн албан хаагчийн тасралтгүй сурч, хөгжих тогтолцоог бүрдүүлж, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлж, нийгмийн баталгааны зохистой бодлогыг баримтална.

10.9. Улаанбаатар, Сэлэнгэ, Дархан, Эрдэнэт зэрэг томоохон хот суурин газруудад байх нутгийн зөвлөлүүдийн бүрэлдэхүүнийг шинэчлэн зохион байгуулж, үйл ажиллагааг тогтмолжуулан, хамтран ажиллана.

АРВАН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ДЭД БҮТЭЦ

11.1. Гэр хорооллын боломжтой хэсгийг инженерийн дэд бүтэцтэй болгох, дахин төлөвлөлтийг хийж, иргэдийг орон сууцжуулах, хаус хороолол бий болгох төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх иргэн, аж ахуйн нэгжийг дэмжин хамтран ажиллана.

11.2. Нийтийн орон сууцны хуучин барилгын гадна фасадыг шинэчлэн засварлах, дулаан алдагдлыг бууруулах ажлыг хувийн хэвшил, иргэдийн оролцоотойгоор хэрэгжүүлнэ.

11.3. Хаягдал бохир ус цэвэрлэх байгууламжийг шинээр барих, өргөтгөх стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламж бий болгох талаар зохих холбогдох байгууллагад уламжилж шийдвэрлүүлнэ.

11.4. Ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламжийг шинэчлэх, өргөтгөх замаар ард иргэдийг шаардлага хангасан ундны усаар хангана.

11.5. Сумын төв болон Рашаант тосгон хоорондох шороон авто замыг засаж сайжруулах, төвүүд дотор хатуу хучилттай авто зам барих ажлыг иргэд олон нийтийн санаачилгад тулгуурлан гүйцэтгэнэ.

11.6. Гудамж талбайн гэрэлтүүлгийг нэмэгдүүлж бүрэн камержуулан, ард иргэдийн аюулгүй байдлыг хангаж, гудамж, талбайн нэр, байшин барилгын хаягийн стандарт хангуулж, хот суурины соёлыг нэмэгдүүлнэ.

11.7. Тоглоомын талбай бүхий соёл амралтын цэцэрлэгт хүрээлэнг бий болгож өргөжүүлнэ.

11.8. Монгол Улсын Засгийн газрын Бүсчилсэн хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсанаар Төв аймгийн Цээл сумаас Орхонтуул сумын нутгаар дайран Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумтай холбох босоо тэнхлэгийн засмал замын ажлын зураг төсөл холбогдох бичиг баримтыг бүрдүүлэн, дээд шатны байгууллагуудаар шийдвэрлүүлнэ.

11.9. Орхон голын төмөр бетон гүүр барих ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, бүх талаар дэмжиж ажиллана.

11.10. Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны барилгыг засварлаж, суралцагчдын амьдрах таатай орчинг бүрдүүлнэ.

11.11. Ерөнхий боловсролын сургуулиудын спорт заалыг сэргээн засварлаж, суралцагчдын сурч хөгжих таатай орчин бүрдүүлнэ.

Орхонтуул сумын МАН-ын Хорооноос 2024 оны Орхонтуул сумын ИТХ-ын ээлжит сонгуульд оролцохдоо дэвшүүлж байгаа сум, орон нутгаа хөгжүүлэх энэхүү зорилтуудыг Та бид хамтран хэрэгжүүлж, ахмад үеийнхээ хөдөлмөрч,

дайчин, шударга уламжлалыг хадгалж, хойч үеийнхээ ирээдүйн сайн сайхны төлөө
Орхонтуул сайхан нутгаа **"ХАМТДАА ХӨГЖҮҮЛЬЕ"**.

**ОРХОНТУУЛ СУМЫН
МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО**

